



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 654

Улаанбаатар хот

“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үйлдвэрийн газрын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2022 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Захирал (Б.Ерөөлт)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ


132007166

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн
67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 он		2022 оны Төлөвлөгөө	Харьцуулалт	
			Төлөвлөгөө	ХБГ		Хувиар (2022төл/ 2021төл/	Дүнгээр (2022төл- 2021төл)
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:						
1	а/ БОАЖЯамнаас эрх шилжүүлсэн NC4/BUR төслийн санхүүжилт	мян.төг	509,608.00	315,188.00	806,288.00	158.22	296,680.00
	б/ БОАЖЯамнаас эрх шилжүүлсэн NAR төслийн санхүүжилт	мян.төг	697,183.00	766,198.00	1,740,000.00	249.58	1,042,817.00
	в/ БОАЖЯамнаас эрх шилжүүлсэн Хамтаран Кредит Олгох Механизм (ХКОМ)-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон санхүүжилт	мян.төг	75,976.00	63,800.00	82,708.80	108.86	6,732.80
	г/ Чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх дэд төслүүдийн санхүүжилт	мян.төг	90,937.00	90,372.00	295,000.00	324.40	204,063.00
2	Нийт төслийн санхүүжилт	мян.төг	1,373,704.00	1,235,558.00	2,923,996.80	212.85	1,550,292.80
3	Нийт зардал	мян.төг	1,370,441.00	1,232,948.00	2,915,551.20	212.75	1,545,110.20
	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	1,370,441.00	1,232,948.00	2,915,551.20	212.75	1,545,110.20
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	3,263.00	2,610.00	8,445.60	258.83	5,182.60
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,936.70	2,349.00	7,601.04	258.83	4,664.34
6	Төсвийн төлбөрийн дүн	мян.төг	122,389.00	101,853.00	195,962.80	160.11	73,573.80
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	-	1,174.50	-	1,174.50
8	Нийт ажилчдын тоо	хүн	18.00	16.00	21.00	116.67	3.00
9	Нийт цалингийн сан	мян.төг	330,831.00	258,291.00	559,016.00	168.97	228,185.00
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,531.63	1,345.27	2,218.32	144.83	686.69
11	Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.00	1.00	1.00	99.95	(0.00)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	32,875.00	14,180.00	12,217.70	37.16	(20,657.30)
13	Нийт авлага	мян.төг	-	-	-	-	-
	Үүнээс: Найдваргүй авлага	мян.төг				-	-
	Нийт өглөг	мян.төг	-	-	-	-	-
14	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	-	-	-	-	-
	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	-	-	-	-	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
6.5.4 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ” ТӨРИЙН
ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
NC4/BUR2 төслийн санхүүжилтээр					
1	Тавилга эд хогшил	Багц	1	3,609.7	3,609.7
2	Зөөврийн компьютер, Dell, i7	ш	1	4,190.0	4,190.0
3	3 үйлдэлтэй принтер, Canon	ш	1	918.0	918.0
Хамтарсан Кредит Механизм олгох нарийн бичгийн газрын санхүүжилтээр					
4	Суурин компьютер, i7	ш	1	3,500.0	3,500.0
НИЙТ ДҮН					12,217.7